



## ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШЛУУЛСАН, ШҮҮХЭЭС ХЭРЭГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН ҮНДЭСЛЭЛ, ШАЛТГААНД ХИЙСЭН ТОЙМ СУДАЛГАА

2015.12.07

Улаанбаатар хот

### УДИРТГАЛ

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн 2015 оны судалгааны төлөвлөгөөнд хийж гүйцэтгэхээр заасан “Шүүх хуралдаан хойшлуулсан үндэслэл, шалтгаанд хийсэн тойм судалгаа”, “Шүүхээс хэрэг түдгэлзүүлсэн үндэслэл, шалтгаанд хийсэн тойм судалгаа”-уудыг нэгтгэн “Шүүх хуралдаан хойшлуулсан, шүүхээс хэрэг түдгэлзүүлсэн үндэслэл, шалтгаанд хийсэн тойм судалгаа”-г хийж гүйцэтгэлээ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /цаашид “ХХША” гэх/-нд байгаа хэргийг шүүх хуульд заасан тодорхой үндэслэл тогтоогдоогүйгээс бусад тохиолдолд эцэслэн шийдвэрлэнэ. Харин практикт шүүх хуралдаан удаа дараалан хойшлох нь ХХША-ны хугацаа хэтрэх, хэргийн оролцогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх явдлыг бий болгож байна. Иймд тус судалгааны хүрээнд анхан шатны шүүхээс шүүх хуралдаан хойшлуулсан, хэргийг түдгэлзүүлсэн үндэслэлийг судлах шаардлагатай болсон юм.

Шүүх хуралдааныг хойшлуулах тухай ойлголт нь хэргийн оролцогчийн хүсэлтээр болон шүүхийн санаачилгаар хойшилж байна. Шүүх бүрэлдэхүүн хэргийг тал бүрээс нь үнэн бодитой шийдвэрлэхийн тулд нотлох баримт бүрдүүлэх, хэргийн оролцогч бүрэн байх шаардлага тавьдаг. Иймд шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч ирээгүй нь мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх боломжгүй болох тул шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно. Процессын хуулиудад шүүх хуралдааныг хойшлуулахгүй байх үндэслэл, шалтгааныг мөн зааж өгсөн. Харин шүүх хэргийн оролцогчийн байдал, хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг хойшлуулах эсэх шийдвэр гаргах бүрэн эрхтэй. Шүүхээс хэрэг түдгэлзүүлэх тухай асуудал нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа /цаашид “ЭБША” гэх/-нд хэрэглэгдэх бөгөөд зөвхөн шүүхээс уг шийдвэрийг гаргахгүй. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хэргийг түдгэлзүүлэх тухай саналаа прокурорт гаргаж, шүүхээс өмнөх шатанд шийдвэрлэх боломжтой. Үүнээс гадна ЭБША-нд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг түдгэлзүүлэх, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ХХША-г түдгэлзүүлэх тухай ойлголт байдаг.

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШЛУУЛСАН ҮНДЭСЛЭЛ, ШАЛТГААН

Шүүх хуралдааныг шүүгч, шүүх бүрэлдэхүүн гагцхүү хуульд заасан үндэслэлийн дагуу хойшлуулна. Хэдийгээр шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэлийг процессын хуулиудад заасан боловч практикт шүүх хуралдааныг удаа дараалан хойшлуулах, улмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа хэтрэх, хэргийн оролцогчдыг чирэгдүүлэх явдал ихээр гарах болжээ. Шүүх хуралдаан хойшлохгүйгээр шийдвэрлэгдэх тохиолдол тун бага байгаа нь шүүх хуралдааныг хойшилж буй үндэслэл, шалтгааныг судлах шаардлагатай болохыг харуулж байна. Нийтлэг байдлаар ХХША /ЭБША/-нд дараах үндэслэлээр шүүх хуралдааныг хойшлуулж байна /Хүснэгт 1/.



## Хүснэгт 1

Д/д	ЭБША-нд шүүх хуралдаан хойшлуулах үндэслэл	Иргэний ХХША-нд шүүх хуралдаан хойшлуулах үндэслэл	Захиргааны ХХША-нд шүүх хуралдаан хойшлуулах үндэслэл
1	Өмгөөлөгч авах хүсэлт гаргасан	Нэхэмжлэлийн шаардлагаа нэмсэн буюу өөрчилсөн	Шүүх хуралдааны оролцогч ирээгүй
2	Өмгөөлөгч өвчтэй	Хэргийн материалтай танилцах хүсэлт гаргасан	Шинжээч томилох, нотлох баримт цуглуулах
3	Шүүгчээс татгалзах тухай хүсэлт гаргасан	Гэрч, гуравдагч этгээд оролцуулах хүсэлт гаргасан	Хариуцагч солих, хариу тайлбар авах
4	Прокурор шүүх хуралдаанд ирээгүй	Өмгөөлөгч авах хүсэлт гаргасан	Хэргийн материалтай танилцах
5	Шүүхийн иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй	Өмгөөлөгчийн хурал давхардсан	Гэрчээс мэдүүлэг авахуулах
6	-	Өмгөөлөгч өвчтэй	Тайлбарыг хүлээн зөвшөөрөх, эвлэрэх
7	-	Хэргийн оролцогч өвчтэй, хуралдааны тов мэдэгдээгүй	Нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх
8	-	Шинжээч томилуулах хүсэлт гаргасан	Гуравдагч этгээдээр татах, шаардлагаа өөрчлөх
9	-	Нотлох баримт гаргуулах хүсэлт гаргасан	Тогтоол, захирамжид гомдол гаргасан
10	-	Шүүгчээс татгалзах тухай хүсэлт гаргасан	Шүүгчээс татгалзах тухай хүсэлт гаргасан
11	-	-	Итгэмжлэлийн хугацаа дууссан
12	ЭБШХ-ийн 240 дүгээр зүйлийн 240.3-д заасан үндэслэл	ИХШХШТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.9-д заасан үндэслэл	ЗХХШТХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.2-т заасан “...нэмэлт нотлох баримт цуглуулах, гэрчийн мэдүүлэг авах, шинжээч томилуулах”
13	ЭБШХ-ийн 243 дугаар зүйлийн 243.1-д заасан үндэслэл	ИХШХШТХ-ийн 90 дүгээр зүйлийн 90.5-д заасан үндэслэл	ЗХХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.7-д заасан “...шинээр нотлох баримт зайлшгүй шаардагдвал”
14	ЭБШХ-ийн 245 дугаар зүйлийн 245.1-д заасан үндэслэл	ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.8-д заасан үндэслэл	ЗХХШТХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.2-т заасан “Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй”
15	ЭБШХ-ийн 258 дугаар зүйлийн 258.2-д заасан үндэслэл	ИХШХШТХ-ийн 105 дугаар зүйлийн 105.2-д заасан үндэслэл	ЗХХШТХ-ийн 63 дугаар зүйлийн 63.6-д заасан “Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэрч, шинжээчийг шүүх хуралдааны танхимаас ...”
16	-	ИХШХШТХ-ийн 131 дүгээр зүйлийн 131.2-т заасан үндэслэл	Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдээгүй, хүрээгүй
17	Бусад	Бусад	Бусад



**1.1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шүүх хуралдаан хойшилж буй үндэслэл, шалтгаан:**

Судалгаанд хамрагдах хугацаанд улсын хэмжээнд анхан шатны шүүхүүд 43631 нэхэмжлэлийг хүлээн авч, 37009 буюу 84.8 хувьд нь иргэний хэрэг үүсгэсэн байна. Харин нийт 41433 шүүх хуралдааныг товлосноос 14940 удаа буюу 36.05 хувьд нь шүүх хуралдааныг хойшлуулжээ. Эндээс товлосон 3 шүүх хуралдааны 1 нь хойшлогдож байгааг харж болно.

Нийслэл дэх Иргэний хэргийн анхан шатны шүүхүүд судалгаанд хамрагдах хугацаанд<sup>1</sup> нийт 24044 хэргийн шүүх хуралдааныг хийхээр товлосноос 11268 удаа шүүх хуралдаан хойшилсон байна.<sup>2</sup> Энэ нь улсын хэмжээнд нийт хойшлогдсон шүүх хуралдааны 75.4 хувийг эзэлжээ. Эндээс шүүх хуралдааныг хойшлуулж буй үндэслэлийг Нийслэл дэх иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн хувьд авч үзье.

**Хүснэгт 2. Иргэний хэргийн шүүх хуралдаан хойшилсон тоон мэдээлэл**

Д/д	Нийслэл дэх Иргэний хэргийн анхан шатны шүүхүүд	Хойшилсон шүүх хуралдааны тоо	Зарласан шүүх хуралдааны тоо
1	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	5802	12130
2	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	5354	10972
3	Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	83	381
4	Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	29	561
	Нийт	11268	24044

Анхан шатны шүүхүүдийн нийт зарласан шүүх хуралдааны тоо 24044 байснаас хойшилсон хуралдааны тоо 11268 буюу 46.8 хувьд нь шүүх хуралдааныг хойшлуулсан байна. Өөрөөр хэлбэл, Нийслэл дэх анхан шатны шүүхүүдэд дунджаар 2 хэргийн нэг нь хойшилж байна гэж үзэж болохоор байна.

Шүүх хуралдааныг хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл шүүхийн санаачилгаар хойшлуулах бөгөөд нийтлэг байдлаар шүүх хуралдаан хойшлуулсан үндэслэлд дараах үндэслэлүүдийг авч үзжээ. Үүнд:

<sup>1</sup>Судалгаа 2014 оны 12 дугаар сарын 22-ноос 2015 оны 11 дүгээр сарын 10-ныг хүртэлх хугацааг хамрав.

<sup>2</sup>“Иргэн-2014” Иргэний хэргийн нэгдсэн систем.

**График 1. Шүүх хуралдаан хойшилж буй үндэслэл, шалтгаан**

Иргэний хэргийн шүүх хуралдаан хойшилж буй үндэслэлийн 63.3 хувь буюу 7132 нь “Хэргийн оролцогчийн хүсэлтээр, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас” хойшилсон байна. Хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт ямар үндэслэлийг хамруулсан талаарх мэдээллийг системээс авч үзэх боломжгүй, мөн хойшилсон хэргийн 18 хувийг эзэлж буй шалтгаан болох “Бусад” гэдэгт ямар шалтгааныг дурдсан болохыг системд оруулаагүй, дутуу оруулсан байх тул нэгтгэн дүгнэх боломжгүй байна.

Харин шүүхийн санаачилгаар хойшилж буй үндэслэлүүдэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид “ИХШХШТХ” гэх/-ийн 38 дугаар зүйлийн 38.9-д заасан “Шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдвал...”, 90 дүгээр зүйлийн 90.5-д заасан “Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэрч, шинжээчийг шүүх хуралдааны танхимаас гаргасан тохиолдолд...”, 100 дугаар зүйлийн 100.8-д заасан “Томилогдсон иргэдийн төлөөлөгч ... хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол...”, 105 дугаар зүйлийн 105.2-д заасан “... нотлох баримтыг шинжлэн судлах шаардлагатай бол...” мөн 131 дүгээр зүйлийн 131.2-д заасан “Гэрлэгчдийн хэн нэг нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол...” гэсэн үндэслэлүүдээр хойшлуулжээ.

Түүнчлэн шүүх хуралдааныг хойшлуулахад процесс ажиллагааны үе шатыг анхааралгүй удаа дараалан хойшлогдон үндэслэл болж буйг дурдах нь зүйтэй юм. Тодруулбал, өмгөөлөгч авах, хэргийн материалтай танилцах, хариу тайлбар ирүүлэх, үнийн дүнг нэмэгдүүлэх зэрэг ажиллагааг тооцох шаардлагатай байна.

### **1.2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шүүх хуралдаан хойшилж буй үндэслэл, шалтгаан:**

Улсын хэмжээнд захиргааны хэргийн анхан шатны шүүхүүд 1883 нэхэмжлэлийг хүлээн авч, 1463 захиргааны хэрэг үүсгэжээ. Харин нийт 8102 удаа шүүх хуралдааныг




хийхээр товлосноос 5428 удаа буюу 70 хувьд нь хойшилсон байна.<sup>3</sup> Өөрөөр хэлбэл, зарлагдсан 3 шүүх хуралдааны 2 нь хойшилж байна. Хэдийгээр ХХША-нд байгаа хэргийн тоо цөөн боловч түүнийг шийдвэрлэхээр зарласан хуралдааны тоо өндөр үзүүлэлттэй харагдаж байгаа нь шүүх хурал ихээр хойшлогдож буйг харуулж байна. Тухайлбал, нэг хэргийн шүүх хурал 5 ба түүнээс дээш удаа хойшлогдох тохиолдол цөөнгүй байна. Энэ нь нэг талаасаа шүүх хуралдааны бэлтгэлийг хангах, зохион байгуулах, нотлох баримтыг хангалттай цуглуулах зэрэг ажиллагааг бүрэн хийлгүйгээр шүүх хуралдааныг товлож байгаатай холбоотой гэж үзэх болохоор байна.

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх судалгаанд хамрагдах хугацаанд<sup>4</sup> нийт 5709 шүүх хуралдааны хэлэлцэхээс товлосноос 4637 удаа шүүх хуралдааныг хойшлуулсан байна. Энэ нь нийт зарлагдсан шүүх хуралдааны 81.2 хувийг эзэлсэн үзүүлэлт юм.

Захиргааны хэргийн шүүхийн хувьд шүүх хуралдаан хойшлох үндэслэлд шүүхээс нотлох баримтыг хангалттай бүрдүүлээгүй үндэслэлээр хойшлуулах боломжтой байдаг нь түүний мөрдөн шалгах зарчимтай холбоотой байдаг. Түүнээс гадна хэргийн оролцогчийн хүсэлтээр Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид “ЗХХШТХ” гэх/-д заасан үндэслэлүүдээр хойшлуулна. Захиргааны хэргийн шүүхийн хувьд нийтлэг байдлаар дараах үндэслэлүүдээр шүүх хуралдааныг хойшлуулжээ.

**График 2. Шүүх хуралдаан хойшилж буй үндэслэл, шалтгаан**



Анхан шатны шүүх ЗХХШТХ-д заасан дараах үндэслэлүүдээс “Шүүхийн санаачилгаар шүүх хуралдаан хойшлуулна”. Тухайлбал, ЗХХШТХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.2-т заасан “...нэмэлт нотлох баримт цуглуулах, гэрчийн мэдүүлэг авах, шинжээч томилуулах”, 31 дүгээр зүйлийн 31.7-д заасан “...шинээр нотлох баримт зайлшгүй шаардагдвал”, 69 дүгээр зүйлийн 69.2-т заасан “Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй”, 63 дугаар зүйлийн 63.6-д заасан “Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэрч, шинжээчийг шүүх хуралдааны танхимаас ...” гэсэн үндэслэл байна. Захиргааны хэргийн шүүхийн хувьд хэргийн үлдэгдэл ихтэй, мөрдөн шалгах зарчмаас үүдэлтэйгээр нотлох баримтыг шүүхээс бүрдүүлэхэд цаг их орох, шийдвэрлэхэд хүндрэлтэй байдаг явдал нөлөөлж байдаг.

<sup>3</sup>Захиргааны хэргийн бүртгэл, хяналтын систем.

<sup>4</sup>Судалгаа 2014 оны 12 дугаар сарын 22-ноос 2015 оны 11 дүгээр сарын 10-ныг хүртэлх хугацааг хамрав.

**1.3. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь шүүх хуралдаан хойшилж буй үндэслэл, шалтгаан:**

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дахь шүүх хуралдаан хойшлуулсан үндэслэл, шалтгааныг судлахад нэлээд төвөгтэй бөгөөд энэ нь эрүүгийн хэргийн нэгдсэн программ байхгүй байгаатай шууд холбоотой юм. Иймд судалгааны хамрах хүрээг зөвхөн нийслэл дэх эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн хүрээнд авч үзлээ.

Нийслэл дэх Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд судалгаанд хамрагдах хугацаанд<sup>5</sup> 47378 шүүх хуралдаан товлосноос 2001 удаа хойшлуулсан нь 45.7 хувийг эзэлжээ. Өөрөөр хэлбэл, 2 хурлын нэг нь хойшилдог үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 2. Эрүүгийн хэргийн шүүх хуралдаан хойшилсон тоон мэдээлэл**

Д/д	Нийслэл дэх Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд	Хойшилсон шүүх хуралдааны тоо	Зарлагдсан шүүх хуралдааны тоо
1	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1068	2370
2	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	868	1770
3	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	22	99
4	Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	43	139
	Нийт	2001	4378

Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1, 2 дугаар шүүхүүд\* 2014 онд 2832 хэргийг шийдвэрлэсэн байх бөгөөд энэ нь улсын хэмжээнд нийт шийдвэрлэсэн хэргийн 44.4 хувийг эзэлсэн байна.<sup>6</sup> Энэ шийдвэрлэсэн хэргийн хувьд их байх тул шүүх хуралдаан хойшлуулж байгаа тоон мэдээлэл мөн өндөр үзүүлэлттэй байхаар байна.

Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн шүүхийн хувьд 2370 шүүх хуралдааныг зарласнаас 1068 удаа буюу 45 хувь, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн шүүх нийт 1770 хуралдаан товлосноос 868 удаа буюу 49 хувь нь тус тус хойшилжээ. Эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг шүүгчдэгчийн хүсэлтээр, шүүхийн санаачилгаар хойшлуулах боломжтой.

Харин ЭБША-нд шүүх хуралдаан хойшлуулж буй дараах нийтлэг үндэслэл, шалтгаан байна. Үүнд:

<sup>5</sup>Судалгаа 2015 оны 01 дүгээр сарын 02-ноос 2015 оны 09 дүгээр сарын 30-ныг хүртэлх хугацааг хамрав.

\*Хуучин нэрээр

<sup>6</sup>Монгол Улсын Шүүхийн тайлан-2014, 169 дэх тал



**График 2. Шүүх хуралдаан хойшилж буй үндэслэл, шалтгаан**



ЭБША-нд нийт хойшлогдсон шүүх хуралдааны 49.3 хувийг өмгөөлөгч өвчтэй, өмгөөлөгчийн хурал давхардсан, өмгөөлөгч авах хүсэлт ирүүлсний улмаас шүүх хуралдааныг хойшлуулжээ. Харин шүүхийн санаачилгаар 18.3 хувийг хойшлуулсан үзүүлэлттэй байна.

#### 1.4. Дүн шинжилгээ

Шүүгч, шүүх бүрэлдэхүүн хэргийг хуульд заасан хугацаанд шийдвэрлэх үүрэгтэй. Харин хуульд заасан тодорхой үндэслэл, шалтгаан бий болсон тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулах нь зүйн хэрэг. Гэвч практикт шүүх хуралдаанууд олноороо хойшлох, олон удаа хойшлуулах нь шүүх эрх мэдлийн нэр хүндийг унагах, шүүн таслах ажиллагаанд иргэдийг чирэгдүүлэх сөрөг хандлагатай юм. Ийнхүү шүүх хуралдаан олноор, удаа дараалан хойшилж буй нь дээр дурдсанчлан эрүү, иргэн, захиргааны хэргийн процессын хуулиудад заасан үндэслэлийн дагуу байхаас гадна шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын зохион байгуулалт сул байх, шүүх хуралдааны бэлтгэл хангалтгүй, шүүх хуралдааны танхим хүрэлцээгүй зэрэг үр дагавраас үүсэлтэй байна.

Нөгөө талаас, хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүх хуралдааныг ихээр хойшлуулж байна. Энэ нь хэргийн оролцогч өвчтэй, итгэмжлэгдсэн төлөөлөгч томилолттой, өвчтэй тул хойшлуулах шалтгаан болж байна. Түүнчлэн өмгөөлөгчийн оролцоотойгоор шүүх хуралдааныг хойшлуулж буй асуудлыг орхилгүй өнгөрч болохгүй. Өмгөөлөгч өөрийн үйлчлүүлэгчид ашигтай байдлыг үүсгэх зорилгоор өвчтэй, хурал давхардсан, өмгөөлөгчөөс татгалзах зэрэг олон асуудлаар шүүх хуралдааныг удаа дараалан хойшлуулах хандлагатай байна.

Дээрх учир шалтгааны улмаас шүүх хуралдаан дараалан хойшилж байх тул цаашид шүүх хуралдаан хойшлуулж буй үндэслэлийг цогцоор нь шийдвэрлэхэд анхаарах нь зүйтэй байна. Мөн судалгаанд хамрагдсан шүүхүүдийн хувьд улсын хэмжээнд шийдвэрлэсэн хэргийн тоон үзүүлэлт өндөр буюу ачаалал ихтэй байх тул шүүгч, шүүхийн



захиргааны ажилтнуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, хэргийн хөдөлгөөний оновчтой менежментийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Иргэн, захиргааны хэргийн хувьд бүртгэл, хяналтын программтай боловч мэдээллээ бүрэн бус оруулах, орхигдуулах зэргээс тоон мэдээлэл хоорондоо зөрүүтэй, буруу байх тохиолдол үүсч байна. Иймд цаашид дээрх программыг таньж мэдэх, ашиглаж сурах зайлшгүй хэрэгцээ бий болжээ. Мөн эрүүгийн хэргийн нэгдсэн программыг бий болгох нь ЭБША-н дахь шүүх хуралдаан хойшлуулж буй үндэслэл, шалтгаан болон процессын олон ажиллагааг судлахад ач холбогдолтой байхаар байна.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ШҮҮХЭЭС ХЭРЭГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН ҮНДЭСЛЭЛ, ШАЛТГААН**

Түдгэлзүүлэх тухай ойлголт нь Иргэн болох захиргааны хэргийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай, харин эрүүгийн хэргийн хувьд хэргийг түдгэлзүүлэх тухай авч үздэг байна. Түүнчлэн эрүүгийн хэргийн хувьд прокурорын шатанд ч хэргийг түдгэлзүүлж болно. Иймд судалгааны хүрээнд шүүхээс хэрэг түдгэлзүүлэх болон, ХХША-г түдгэлзүүлэх асуудлыг аль алиныг нь авч үзлээ. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд шийдвэрлэх хуулийн зохицуулалт нь ИХШХШТХ-иар зохицуулагдах тул иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай төстэй юм.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн шалтгаан арилмагц хэргийн оролцогчийн хүсэлт буюу өөрийн санаачилгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээн явуулах тухай шүүгч захирамж гаргах ба энэ өдрөөсөхлэн хэрэг хянан шийдвэрлэх хугацааг үргэлжлүүлэн тоолно. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн шалтгаан шүүгчийн заасан хугацаанд арилаагүй бол шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээж, хэргийг хэрэгсэхгүй болгох захирамж гаргах бөгөөд захирамжид хэргийг шийдвэрлэхэд саад болж байгаа нөхцөл, түүнийг хэрхэн засах талаар тусгана.

### **2.1. Иргэний ХХША-г түдгэлзүүлсэн үндэслэл, шалтгаан**

ИХШХШТХ-д зааснаар ХХША-г түдгэлзүүлэх тухай ойлголт бий. Тус хуулийн 80 дугаар зүйлд заасан үндэслэлийн дагуу шүүхээс түдгэлзүүлнэ. Тухайлбал, Зохигч болох хүн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан үед маргаантай байгаа шаардлага буюу үүрэг эрх залгамжлагчид шилжих ёстой. Татан буугдсан зохигчийн эрх, үүргийг эрх залгамжлагч шилжүүлэн авах боломж үүссэн үед хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эрх үүргийг шилжих хүртэл түдгэлзүүлнэ<sup>7</sup>. Өөрөөр хэлбэл, хууль ёсны дараагийн эрх залгамжлагч тодрох хүртэл хэргийг шийдвэрлэхгүй бөгөөд энэ хугацаа нь ХХША-ны хугацаанд хамаарахгүй.

<sup>7</sup>Процессийн эрх зүй-онол, туршлага, 2014, УБ., 244 дэх тал






Д/д	Нийслэл дэх Иргэний хэргийн анхан шатны шүүхүүд	Түдгэлзүүлсэн хэргийн тоо	ХХША дахь хэргийн нийт тоо
1	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	387	10891
2	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	377	9619
3	Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	34	711
4	Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	6	801
	Нийт	804	22022

Улсын хэмжээнд иргэний хэргийн анхан шатны шүүхүүд дээрх хугацаанд 37006 хэрэг ХХША-нд байснаас 1524 буюу 4.1хувийг түдгэлзүүлсэн үзүүлэлттэй байна. Харин Нийслэл дэх иргэний хэргийн анхан шатны шүүхүүд нийт 22022 хэрэг ХХША-нд байсан бөгөөд үүний 804 буюу 3.6 хувийг нь түдгэлзүүлжээ.<sup>8</sup> Шүүхээс дараах үндэслэлээр ХХША-г түдгэлзүүлсэн байна.

График 3. ХХША түдгэлзүүлсэн үндэслэл, шалтгаан



<sup>8</sup>"Иргэн-2014" Иргэний хэргийн нэгдсэн систем.




Нийслэл дэх Иргэний хэргийн анхан шатны шүүхүүд ХХША-г түдгэлзүүлсэн үндэслэлийн 748 буюу 93 хувийг ИХШХШТХ-ийн 80 дугаар зүйлийн 80.1.8 дахь хэсэгт заасан "энэ хуулийн 39, 41, 47 дугаар зүйлд заасан ажиллагаа явуулж байгаа бол" гэсэн үндэслэл эзэлсэн байна. Энэ нь шинжээч томилж, дүгнэлт гаргуулах ажиллагаа явагдаж байгаа тул шинжээчийн дүгнэлтийг шүүхэд ирүүлэх хүртэл, нотлох баримтыг өөр орон нутгаас бүрдүүлэх ажиллагаа хийгдэж байх тул түдгэлзүүлжээ.

## 2.2. Захиргааны ХХША-г түдгэлзүүлсэн үндэслэл, шалтгаан

Улсын хэмжээнд захиргааны хэргийн анхан шатны шүүх судалгаанд хамрагдах хугацаанд ХХША-нд 1463 хэрэг байснаас 137 буюу 9.3 хувийг түдгэлзүүлжээ. Харин Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх 953 захиргааны хэрэг ХХША-нд байсны 71 буюу 7.4 хувийг түдгэлзүүлсэн үзүүлэлттэй байна.

Захиргааны хэргийн хувьд ИХШХШТХ-ийн 80 дугаар зүйлд заасан үндэслэлээр ХХША-г түдгэлзүүлэх тул шалтгааны хувьд төстэй байдаг. Үүнд:

График 4. ХХША түдгэлзүүлсэн үндэслэл, шалтгаан



Иргэний хэргийн шүүхийн ХХША-г түдгэлзүүлсэнтэй ижил захиргааны ХХША-нд нотлох баримт бүрдүүлэх, шинжээчийн дүгнэлт гартал түдгэлзүүлэх тухай асуудал нийт түдгэлзүүлсэн хэргийн 90 хувийг эзэлжээ.

## 2.3. ЭБША-н дахь хэргийг түдгэлзүүлсэн үндэслэл, шалтгаан

Дээр дурдсанчлан ЭБША-нд хэргийг түдгэлзүүлэх тухай ойлголт бий. Энэ нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан тодорхой үндэслэл, шалтгаантай. Тухайлбал, яллагдагчийн хаана байгаа нь мэдэгдэхгүй байх, яллагдагч сэтгэцийн болон бусад хүнд өвчний улмаас хүрэлцэн ирж чадахгүй болох нь шинжээчийн дүгнэлт, эсхүл эмнэлгийн байгууллагын тодорхойлолтоор нотлогдсон байх зэрэг үндэслэлүүд байна.



Хүснэгт 4.

Эрүүгийн хэргийг түдгэлзүүлсэн үндэслэл, шалтгаан

Д/д	Нийслэл дэх Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд	Түдгэлзүүлсэн хэргийн тоо <sup>9</sup>	ХХША дахь хэргийн нийт тоо
1	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	6	2370
2	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	1770
3	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	-	99
4	Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	139
Нийт		8	4378

Хэргийг зөвхөн шүүхээс түдгэлзүүлэхгүй бөгөөд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн саналаар прокурор түдгэлзүүлж болно. Судалгааны хүрээнд зөвхөн шүүхээс түдгэлзүүлсэн үндэслэл, шалтгааныг судалсан болно.

Шүүхээс эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх тухай асуудал цөөн тоотой байх бөгөөд үндэслэлийн хувьд ЭБШХ-ийн 229 дүгээр зүйлийн 229.1.2 дахь хэсэгт заасан “яллагдагч сэтгэцийн болон бусад хүнд өвчний улмаас хүрэлцэн ирж чадахгүй болох нь шинжээчийн дүгнэлт, эсхүл эмнэлгийн байгууллагын тодорхойлолтоор нотлогдсон бол”, мөн тус хуулийн 229 дүгээр зүйлийн 229.1.1 дэх хэсэгт заасан “яллагдагчийн хаана байгаа нь мэдэгдэхгүй байгаа бол” гэсэн үндэслэл, шалтгааны улмаас хэргийг хойшлуулсан байна.

Үүнээс гадна Шүүн таслах ажиллагааны сүүлийн тайлангуудад хэргийн үлдэгдэл дэх хойшлуулсан, түдгэлзүүлсэн хэргийн тоо өссөн үзүүлэлттэй байна. Мөн 2015 оны эхний хагас жилд өссөн байгааг харж болно.

Утга		2012 он	2013 он	2014 он	2015 он х/ж	Нийт
<b>Иргэн</b>	Хойшлуулсан	335	458	893	552	2238
	Түдгэлзүүлсэн	534	584	590	680	2388
<b>Захиргаа</b>	Хойшлуулсан	70	168	176	199	613
	Түдгэлзүүлсэн	47	64	105	113	329
<b>Нийт</b>		<b>986</b>	<b>1274</b>	<b>1764</b>	<b>1544</b>	<b>5568</b>

Иргэн, захиргааны хэргийн хэргийн үлдэгдэл сүүлийн жилүүдэд өссөн үзүүлэлттэй байх бөгөөд үүний дотор шүүх хуралдаан хойшлуулсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн тоон мэдээллийг судаллаа. Иргэн, захиргааны хэрэг дэх хэргийн үлдэгдэлийн шүүх хуралдаан хойшлуулсан, ХХША түдгэлзүүлсэн тоо байнгын өссөн дүнтэй байна. Энэ нь дээрх үндэслэл, шалтгааны улмаас шүүх хуралдааныг хойшлуулах, ХХША-г түдгэлзүүлэх асуудал нэмэгдэж байгааг харуулж байна.

<sup>9</sup>Судалгааг Нийслэл дэх Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдээс ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан хийв.



#### **2.4. Дүн шинжилгээ**

Шүүхээс хэргийг түдгэлзүүлэх тухай ойлголт нь ЭБША-нд хэрэглэгдэх бөгөөд иргэн, захиргааны хэргийн хувьд ХХША-г түдгэлзүүлнэ. Харин хэргийг зөвхөн шүүхээс түдгэлзүүлэхгүй бөгөөд прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд түдгэлзүүлж болно. ХХША-г түдгэлзүүлэх тухай асуудлын хувьд иргэн болон захиргааны хэргийн хувьд нэг хуулийн зохицуулалттай байх тул ерөнхийдөө төстэй байна. Тухайлбал, иргэн болон захиргааны хэргийн шүүхийн ХХША-г түдгэлзүүлсэн үндэслэлийн хувьд ИХШХШТХ-ийн 80 дугаар зүйлийн 80.1.8-д заасан “нотлох баримт бүрдүүлэх, шинжээчийн дүгнэлт гарах хүртэл” гэсэн үндэслэлээр голчлон хэргийг түдгэлзүүлж байна. Харин ЭБША-нд хэргийг түдгэлзүүлэх үндэслэл харьцангуй цөөн байгааг харж болно.

Судалгааны хүрээнд шүүхээс хэрэг /ХХША/ түдгэлзүүлэх, шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэлийг эрүү, иргэн, захиргааны шүүхийн хувьд тус бүрд нь авч үзэж, дүн шинжилгээ хийхийг зорьлоо. Зарим тохиолдолд шүүхүүдээс авсан тоон мэдээлэл систем дэх дүнтэй зөрүүтэй байсан тул системээс авсан мэдээлэлд тулгуурлан дүн шинжилгээ хийсэн болно. Шүүхүүдээс мэдээллийг ирүүлэхдээ алдаатай, дутуу, бүрэн бус мэдээлэл ирүүлж байх тул цаашид судалгааг гаргаж өгөх асуудалд ач холбогдолтой хандах нь зүйтэй байна.

Тойм судалгааны хүрээнд илүүтэй шүүх хуралдааныг хойшлуулсан, шүүхээс хэрэг, ХХША-г түдгэлзүүлсэн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн бөгөөд цаашид энэ талаар дэлгэрэнгүй судлах нь иргэдийн эрх, эрх чөлөөг сахиулан хамгаалахад өндөр ач холбогдолтой бөгөөд нөгөө талаас шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудад хариуцлага тооцохнэг алхам болно гэж үзэж байна.